



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 07/2014

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсад Нисэх хүчин үүсч хөгжсөний 93 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Г.Батбаяр	Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Алтантуул	Хэвлэх цехийн хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ч.Нямсүрэн	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
	Ё.Эрдэнэбат	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
	Д.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
	Г.Ганхуяг	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны менежер
	Д.Ариунтуяа	Захиргаа, удирдлагын газрын захиргаа, хүний нөөцийн менежер
	Э.Энхзориг	Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх тасгийн дарга

Ц.Болдсүрэн	Аж ахуйн тасгийн дарга
Г.Бат-Алдар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Г.Ундраа	Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн маркетингийн мэргэжилтэн
Д.Мөнхбаатар	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын захирал
П.Ариунгэрэл	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга
Д.Баяртогтох	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны дарга
П.Мөнхжаргал	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга
С.Нацагдорж	Газрын тусгай үйлчилгээний албаны дарга
Б.Пүрэвсүрэн	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Хэвлэл мэдээлэл хуулийн хэлтсийн дарга

2. Нисэх хүчин үүсч хөгжсөний 93 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын төсвийг 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн дотор боловсруулж батлуулахыг Ажлын хэсэг /Г.Батбаяр/-т үүрэг болгосугай.

3. Ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах зардлыг төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА  Л.БЯМБАСҮРЭН